



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 1/53

Номгон

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ерөнхий боловсролын сургуулиудад хадгалагдаж байгаа химийн хорт болон аюултай бодисын хадгалах, ашиглах үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Р.Мэндбаяр-(Тагнуулын ерөнхий газрын Баянхонгор аймаг дахь Тагнуулын хэлтсийн дарга, дэд хурандаа)

Гишүүд:Г.Бямбасүрэн-(Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

Г.Одонтунгалаг-(Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтэн)

Д.Мөнхтуяа-(Нэгдсэн эмнэлгийн онош зүйн тасгийн эрхлэгч)

Нарийн бичгийн дарга: Б.Дарханбаяр (Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч)

2. Химийн хорт болон аюултай бодисын хадгалах, ашиглах үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, цаашид авч хэрэгжүүлэх ажлын танилцуулгыг 2022 оны 02 дугаар сарын 28-ны дотор танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь )-т даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

601220135